



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 05 сарын 23 өдөр

Дугаар А/304

Хэрлэн сум

Нээлттэй хэнтий өдөрлөгт
хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 3 дугаар сарын 09-ний өдрийн 02 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Улаанбаатар хотод 2023 оны 5 дугаар сарын 27-ны өдөр Нээлттэй хэнтий өдөрлөг зохион байгуулах үйл ажиллагаанд 23,390,000 (хорин гурван сая гурван зуун ерэн мянга) төгрөгийг зарцуулсугай.

2. Зардлын тооцоог хавсралтаар баталсугай.

3. Дээрх үйл ажиллагааны зардалд шаардагдах хөрөнгийг аймгийн Засаг дарга дансны нээлттэй Хэнтий аймаг хөтөлбөр хэрэгжүүлэх зардлаас санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтэс (С.Нямдаваа), захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (Л.Батсайхан)-д тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ЧОГСОМЖАВ

Аймгийн Засаг даргын 2023 оны
05 дугаар сарын 22-ны өдрийн
А/304 дугаар захирамжийн хавсралт

Нээлттэй хэнтий өдөрлөг арга хэмжээний зардлын тооцоо

| № | | Нэг бүрийн үнэ | Тоо хэмжээ | Дүн |
|----|--|----------------|------------|------------|
| 1 | Шовгор асар түрээслэх зардал/3x3/ | 165,000 | 28 | 4,620,000 |
| 2 | Ширээ түрээслэх зардал /1.2 м/ | 27,500 | 54 | 1,485,000 |
| 3 | Саңдал түрээслэх зардал | 5,500 | 390 | 2,145,000 |
| 4 | Тайзны түрээсийн зардал /лед. Хөгжимтэй/ | 1,500,000 | 1 | 1,500,000 |
| 5 | Хөргүүр | 100,000 | 4 | 400,000 |
| 6 | Фудволк | 25,000 | 25 | 625,000 |
| 7 | Таваг | 10,000 | 7 | 70,000 |
| 8 | Тавгийн ааруул | 25,000 | 5 | 125,000 |
| 9 | Шовгорын баннер | 30,000 | 28 | 840,000 |
| 10 | Станд | 60,000 | 7 | 420,000 |
| 11 | Боршур | 500 | 7,500 | 3,750,000 |
| 12 | Баннерийн хөл | 200,000 | 2 | 400,000 |
| 13 | Автобусны тээврийн зардал | | | 4,500,000 |
| 14 | Тугны ишний түрээс, туг | | | 1,850,000 |
| 15 | Бусад зардал | | | 660,000 |
| | Нийт дүн | | | 23,390,000 |